



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/51

Дадал сум

**Хурдан морины уралдаан зохион
байгуулахыг хориглох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Хүүхдийн Эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд бооцоот болон хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг жил бүрийн 11 дүгээр сарын 01-нээс дараа оны 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хориглосугай

2.Орон нутагт зохион байгуулах хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээг цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан, холбогдох хууль журмын дагуу зөвшөөрөл авч зөвшөөрөгдсөн хуулийн хугацаанд зохион байгуулж байхыг "Сантхаан" уяачдын холбоонд, хориглосон хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээг зохион байгуулахгүй байхад хяналт тавьж, захирамжийг мөрдүүлж ажиллахыг багийн Засаг дарга нарт болон Хэсгийн төлөөлөгч (Г.Билгүүн)-д даалгасугай.

3.Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг таслан зогсоох арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, өвөл, хаврын улиралд зохион байгуулагдах хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээнд 18 нас хүртэлх хүүхдийг аливаа хэлбэрээр оролцуулахгүй байхад хяналт тавьж ажиллахыг Нийгмийн ажилтан (Б.Мөнхзул), хэсгийн төлөөлөгч (Г.Билгүүн)-д нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000177